



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 8/46

Хэрлэн сум

Г.Гансүхэд сахилгын
шийтгэл ногдуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 65 дугаар зүйлийн 65.3.1, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Сумын “Хогийн цэгийг хашаажуулах, камержуулах” ажлын худалдан авах ажиллагааг нээлттэй, тод зарлаж зохион байгуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалтуудыг зөрчсөн тухай аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны 253/A2370454 дүгээр албан шаардлагын дагуу Батширээт сумын Засаг дарга Г.Гансүхэд сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Албан үүргээ холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд биелүүлж ажиллахыг Батширээт сумын Засаг дарга Г.Гансүхэд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Ж.Гантулга)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ